

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.

БАТЛАВ:
“ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.ГАНХҮҮ

Барилга, байгууламж нь дараах техникийн тодорхойлолтод нийцсэн байна.

2024.06.18

| № | Барилга байгууламж | Тоо хэмжээ | Тавигдах шаардлага |
|---|--------------------|---|---|
| 1 | Оффисын байр | 500-550м ² - аас багагүй байх. | <p>Нэг: Байршил</p> <ol style="list-style-type: none">1.1. Оффисын байр нь Улаанбаатар хотын “А” бүсэд буюу төв цэгээс 500 (таван зуу)-н метрийн радиус дотор байрлалтай байх. Төв цэгийн координат: 47°55'06.7"N 106°55'03.8"E1.2. Авах оффисын талбай нь нэгдсэн нэг давхарт үргэлжилсэн байрлалтай байх.1.3. Оффис үйлчилгээний зориулалттай, үзэгдэх орчин сайтай, техникийн болон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байх.1.4. Ажлын байрны өрөө, тасалгаанд зохион байгуулалт хийх уян хатан байдал болон дотоод засал хийгдсэн байх.1.5. Барилгын 8 дугаар давхраас дээш давхарт байрлалтай байх.1.6. Зөвхөн санал болгож буй оффисын байрны давхарт зогсох боломжтой цахилгаан шаттай байх. <p>Хоёр: Инженерчлэл</p> <ol style="list-style-type: none">2.1. Аюулгүй байдал бүрэн хангасан, дулаан алдагдал багатай бүрэн цутгамал хийцлэлтэй байх (шилэн фасадгүй).2.2. Оффисын байр нь дулаан, цахилгаан, усан хангамжийн болон бусад дэд бүтцийн систем холбогдсон байх.2.3. Худалдан авах талбайн байрлах давхарт кабелин телевиз, интернэт, телефон утасны сүлжээ бүрэн орсон байх.2.4. Барилгын дотоод сүлжээний сувагчлалын дэлгэрэнгүй мэдээлэл, барилгын шилэн кабелийн холболтын мэдээлэл ирүүлэх.2.5. Цахилгааны монтаж, газардуулах байгууламжид засвар үйлчилгээ, хэмжилт туршилт хийлгэж норм хэмжээнд оруулсан дүгнэлттэй байх, хэт хүчдэл, богино залгааны гүйдлээс хамгаалах тоноглолоор цахилгааны хуваарилах самбарууд тоноглогдсон байх /Барилгын цахилгааны үндсэн шийдлийг харуулсан ерөнхий зураг ирүүлэх/.2.6. Цахилгааны монтаж, сүлжээ ажлын онцлогт тохирсон, ачаалал даах хэмжээнд байх.2.7. Цахилгаан, сантехникийн болон бусад засвар |

| | | | |
|--|--|--|--|
| | | | <p>үйлчилгээг үзүүлэх чадвартай мэргэжлийн багтай байх.</p> |
| | | | <p>Гурав: Дотор орчин</p> <p>3.1. Техникийн серверийн өрөөтэй байх.</p> <p>3.2. Оффисын байр, тасалгааны дулаан, агааржуулалтын систем стандартын шаардлагад нийцсэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх.</p> <p>3.3. Ажлын байрны зориулалтаар иж бүрэн тоноглогдсон агааржуулалтын систем, нэгж талбайд ногдох хөргөлт агааржуулалтын системтэй байх.</p> <p>3.4. Өрөөнүүдийн халаалтын радиатор тохируулга, термостаттай байх.</p> <p>3.5. Өрөө тасалгааны гэрэлтүүлэг хангалттай тод тусгалтай, эвдрэл, гэмтэлгүй байх.</p> <p>3.6. Барилгын дотор авто зогсоолд хангалттай тооны автомашины зогсоолтой байх.</p> <p>3.7. Барилгын шат, хонгилд галын аюулаас урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл, дохиолол, галын хор байршуулсан байх.</p> <p>3.8. Байгалийн гамшиг, аюул учирсан тохиолдолд нүүлгэн шилжүүлэх аваарын гарц /аврах хаалга болон галын шат/-тай байх.</p> <p>3.9. Галын аюул, гамшгийн дуут дохио зарлан мэдээлэх системтэй байх.</p> <p>3.10. 24 цагийн харуул хамгаалалт, хяналтын камер, хаалгач болон угтах үйлчилгээтэй байх.</p> <p>3.11. Эрэгтэй, эмэгтэй тусдаа ариун цэврийн өрөөтэй байх /тус бүрдээ 2-оос доошгүй тасалгаатай суултууртай, угаалтуур нь халуун, хүйтэн устай, стандартад нийцсэн агааржуулалттай байх/.</p> <p>3.12. Барилга нь барьж ашиглалтанд орсноос хойш 3 болон түүнээс доош жилтэй.</p> |
| | | | <p>Дөрөв: Гадна орчин</p> <p>4.1. Барилга дотроо олон нийтийн үйл ажиллагаа, олон улсын хурал, уулзалт зохион байгуулах боломжтой тоног төхөөрөмжөөр тоноглогдсон танхимтай байвал давуу тал гэж үзнэ.</p> |

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

| № | Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.) | Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.) | Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана) |
|----------|--|--|---|
| 1 | | | |
| 2 | | | |
| 3 | | | |
| ... | | | |

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]